



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БАТШИРЭЭТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 05 сарын 05 өдөр

Дугаар А/81

Батширээт сум

**Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх
дархлаажуулалт, лабораторийн шинжилгээний ажлыг
зохион байгуулах тухай**

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, 9.2, 9.3, 9.4, 9.5, 9.6, 9.7, 9.8, 9.9, 21 дүгээр зүйлийн 21.1, 21.3 дахь хэсэг, 28 дугаар зүйлийн 28.4, Аймгийн Засаг даргын 2025 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн А/212 дугаар захирамжийг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ** нь:

1. Мал, амьтныг халдварт өвчнүүдээс урьдчилан сэргийлж дархлаажуулах, шимэгчтэх өвчнөөс эмчлэн сэргийлэх угаалга, туулгалт, боловсруулалт, лабораторийн оношлон, тандах шинжилгээ хийх ажлыг 2025 оны 05 дугаар сарын 05-наас 2025 оны 11 дүгээр сарын 01-ийг хүртэлх хугацаанд чанартай, маршрутын дагуу хийж гүйцэтгэх, туслах ажилчдын хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангаж, зааварчилга өгч ажиллахыг Баянбараат Хайрхан ХХК-ийн захирал (Т.Бямбадорж), Шүтээн дэнж ХХК-ийн захирал (Б.Мягмаржав), "Өглөгч сүрэгХХК"-ийн захирал Ц.Ариунболд нарт тус тус үүрэг болгосугай.

2. Урьдчилан сэргийлэх тарилганд, туулгалт угаалга, боловсруулалтанд мал сүргээ товлосон хугацаанд тарилгын хашаа бүхий газар авчирч бүрэн хамруулж, тарилгын явцад малын эмч мэргэжилтнүүдэд туслалцаа үзүүлэн хамтран ажиллах, тарилгад хамрагдсанаас хойш 14-21 хоногийн хугацаанд малын гаралтай бүтээгдэхүүн мах, сүүг зах зээлд борлуулахгүй байхыг нийт малчид, мал бүхий иргэдэд даалгасугай.

3. Урьдчилан сэргийлэх ажил явагдах хугацаа болон мал, амьтныг мал эмнэлгийн арга хэмжээнд бүрэн хамруулж ажиллах талаарх мэдээллийг малчдад хүргэж ажиллахыг багийн Засаг дарга нарт, мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээнд мал сүргээ бүрэн хамруулахаас зайлсхийсэн малчин, мал бүхий иргэд, заавар журмыг баримтлаагүйн улмаас малын өвчин гарах нөхцөлийг бүрдүүлсэн албан тушаалтанд хуулийн хариуцлага тооцож ажиллахыг Мал эмнэлгийн Улсын байцаагч (У.Ундрах)-д үүрэг болгосугай.

4. Мал эмнэлгийн арга хэмжээний явц гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг Мал эмнэлгийн Улсын байцаагч (Ж.Ундрах)-д, графикт хугацаанд нь шуурхай зохион байгуулж малчид, мал бүхий иргэдийг татан оролцуулах, тээврийн хэрэгсэл хүн хүчээр хангаж ажиллахыг Засаг даргын орлогч (Б.Төрмөнх)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.АЛТАНГЭРЭЛ

232501189